

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

ХАЛХ ГОЛЫН БАЙЛДААНЫ ТУХАЙ ЯПОНЫ ХЭВЛЭЛД

Г. Зориг

Энэ онд Монголын ард түмэн Халх голын түүхэн ялалтын 45 жилийн ойг тэмдэглэх гэж байна. Уг ялалт БНМАУ-ын шинэхэн түүхэнд ихээхэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон билээ. 1939 онд японы түрэмгийлэгчдийг Халхын голд бут цохисон нь БНМАУ, ЗСБНХУ-ын ах дүүгийн эвдэршгүй ган бат найрамдал, эв санааны дайчин нэгдэл, эх оронч дайчдын эрэлхэг зоригтойн шалгуур болж империалист түрэмгийллийн өөдөөс хоёр орны ард түмний интернационалч эрх ашиг, ангич байр суурь, нэгдэл нягтралын ялагдашгүй хүч сөрөн зогссоныг дэлхий нийтэд тов тодорхой харуулж өгсөн юм.

1939 оны Халх голын дайны бодит үйл явдлыг монгол, зөвлөлтийн түүх бичлэгт олон удаа дэлгэрэнгүй тусгасан юм.¹ Японы зэвсэгт түрэмгийлэл үүссэн шалтгаан, монгол-зөвлөлтийн армиудын байлдааны болон тактикийн үйл ажиллагаа, түрэмгийлэгчийн ялагдал ба Халх голын ялалтын түүхэн ач холбогдлын талаар монгол зөвлөлтийн эрдэмтэд санал нэгтэй байдаг юм. Харин уг сэдвээр японы түүх бичлэгт ихээхэн зөрөөтэй зүйлүүд бичигддэг юм. Энэ асуулдаар бичигдсэн зарим ном зохиолд дүн шинжилгээ хийж үзвэл, 1939 онд Монголын хил дээр болсон түүхэн үйл явдлыг тусгаж байгаа Японы талын судалгаа нь үндсэн хоёр чиглэлтэй байгааг харж болно. Нэгдүгээрт, түүхэн баримт бичигт тулгуурласан, нэлээд үндэслэлтэй объектив чиглэл байна. Энэ чиглэлийн ном зохиолд БНМАУ-ын эсрэг Японы түрэмгийллийн тухай илэн далангүй бичихийн зэрэгцээ Халх голын тулалдааныг Алс Дорнод дахь тэр үеийн олон улсын харилцаатай холбож үзсэн байдаг. Үүнд японы монголч эрдэмтэн Кацухико Танакагийн бичсэн өгүүллийг оруулж болох юм.² Гэвч иймэрхүү зохиол ховор байгаа төдийгүй японы уншигч олон эдгээрийг бараг мэдэхгүй байна.

Хоёрдугаар чиглэл нь субъектив шинжтэй юм. Энд гол төлөв олон тоогоор хэвлэгдэн гарч буй дурсамжийн зохиолууд орж байна. Иймэрхүү номонд японы түрэмгийллийн бодит шалтгааныг хөндөөгүй. Халх голын дайныг тэр үеийн японы милитарист гадаад бодлогоос салангид авч үзсэн. Зөвлөлт-Монголын армийн хүчийг үл тоомсорлосон зэрэг байдал бичигдсэнээс гадна дайнд ялагдсаны шалтгааныг Квантуны армийн командлал ба жанжин штабын хооронд үл итгэлцэх байдал ба үйл ажиллагааны сул дорой тал байснаас болсон мэтээр

¹ И. И. Ростунов. «Боевые действия на р. Халхин-Гол в советской историографии. «Победа на реке Халхин-гол» М., 1981, 49—60-р тал. «Халх голын байлдаан» УБ., 1970 он. Ц. Самдангэлэг «Зөвлөлт-монголын армиуд Халх голд Японы түрэмгийчүүдийг бут цохисон нь». УБ., 1981. БНМАУ-ын түүх III боть. УБ., 1969 гэх зэрэг. «»

² Танака К., Согэн то какүмэй (Тал нутаг ба хувьсгал) Токио, 1975.

тайлбарлаж байна.³ Дайны сэдвээр Японы бичигдэж байгаа олонхи ном зохиол нь шууд буюу шууд бус байдлаар БНМАУ-ын түүх, Алс Дорнодын олон улсын харилцааны түүхийг ихэнхдээ гуйвуулж байна. Тэнд их хэмжээгээр хэвлэгдэж байгаа номуудын олонхи нь түүхэн үйл явдлын талаар ээдрээтэй ойлголтыг уншигчдад төрүүлэх, Японд милитарист, хонзогногч үзэл санааг сэргээн дэвэргэх явдлыг тойруу замаар дэмжихэд зориулагдаж байдаг юм.

Иймэрхүү ном зохиолд Халх голын дайныг 1) хилийн тодорхой шугам байгаагүй, 2) монгол цэргүүд хил зөрчсөн, 3) Япон, Манж-го хоёрын талаар ЗХУ, БНМАУ-аас явуулсан эзлэн түрэмгийлэх бодлогын улмаас үүдэн гарсан хилийн будлиан байсан мэтээр голдуу үзүүлсэн байдаг.

Дайн үүссэн шалтгааны тухай Японд хамгийн түгээмэл дэлгэрсэн номнол нь монгол цэргүүд морио услахаар хил зөрчиж манжийн харуулд баригдсанаас болсон мэтээр үзүүлэх гэж оролдох явдал юм. Тэдгээрийг чөлөөлөхийн тулд монголын армийн нэгэн хэсэг Манж-Гогийн хил зөрчиж манжийн харуулыг довтолсон. Үүнээс болж дайн эхэлсэн юм.⁴ Номонханы орчимд хилийн будлиан үүссэн нь улсын хилийн шугам тодорхой бус байсантай холбоотой юм⁵ гэж Японы хэвлэлүүд тайлбарласаар байна. Харин Японы «Тоё» сэтгүүл дайн үүссэн шалтгааныг өөр маягаар тайлбарлахыг оролдож байна. Буйр нуурын орчим нутаг үржил шимтэй, өвс ургамал элбэг, тохиромжтой бэлчээрээрээ эрт дээр үеэс алдаршсан юм. Ийм учраас нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчууд дээр үеэс энэ нутагт санаархдаг байжээ. Иймээс уг мөргөлдөөн (1939 оны 5-р сарын явдал—Г.3) энэ нутгийг өөрийн болгох гэсэн монголчуудын санаархалтай шууд холбоотой эхэлсэн гэж хэлж болох юм⁶ гэжээ. Бодит байдлыг ийнхүү мушгин гуйвуулсан нь бүхэлдээ субъектив шинж чанартай юм. Ийм маягийн нийтлэлүүд нь Японд милитаризм сэргээж байгааг ард түмнээсээ нуух, Халх гол дахь японы түрэмгийллийг Манж-Го-гийн хувьд Япон улс «холбоотны үүрэг» гүйцэтгэсэн хариу арга хэмжээ байсан мэтээр дүрслэн харуулах зорилго агуулж байгаа юм. Японы талын тайлбарлаж байгаагаар Монгол, Манж-го хоёрын хооронд улсын хил нь байгалиас тогтсон Халх голын дагуу байсан. Уг мөргөлдөөн Халх голын зүүн эрэг дээр болсон учир монгол-зөвлөлтийн түрэмгийлэл бүр ч тодорхой байна гэх мэтээр тайлбарлахыг оролдсоор байна.

Үнэндээ бол энэ нутгийн хил нь манж Чин улсын үед Монголд засаг захиргааны өөрчлөлтүүд хийсэн тэр үеэс бүрэлдэн тогтсон юм. Үүнийг түүхэн олон баримт нотолдог билээ.

Монголд ардын хувьсгал ялсны дараа Ар Монголын хил хязгаар урьдын адил хэвээр үлдэж БНМАУ-ын хил болсон билээ. Хилийн шугамыг газар дээр нь овоогоор буюу хилийн баганаар тэмдэглэж байжээ. Номонханы орчим газарт хилийн шугам Халх голоор биш, харин түүнээс зүүн тийш 20—22 км зайтай байв. К. Танака бичихдээ: «Монгол—Манжийн хил нь Номонхан-Бүрд овоо, Хайластын гол хоёрын дунд Халх голоос зүүн тийш 22 км зайд оршдог юм. Тэнд овоо бүрийн хооронд 1—1,5 км зайтай 2,5—3 м өндөр тус бүр дугаартай хилийн багана байдаг. 1939 онд Халх голын баруун эрэг дээр 150—200 хүнтэй монголын хилийн 7-р застав байрлаж байв. Энэ застасаас өдөр бүр Халх голын зүүн эргийг тойрч шалгадаг байжээ. Япон-Ман-

³ Жишээнд: Э. Тэрада. «Номонхан-но синсо» (Номонханы тухай үнэн) Токио. 1981. 2-р тал.

⁴ Одзава Т. «Номонхан сэнки» (Номонханы дайны тэмдэглэлүүд) Т. 1976 30-р тал. Сива Р. «Гайто-о юку» (Замаар одохуйд) Т. 1974 он.

⁵ «Тоё». «Монгол-Манжийн хилийн будлианы тухай».

⁶ «Тоё» 1939 он. 7-р сар. 131-132-р тал.

жийнхан хилийн будлиан тасралтгүй үйлдэж эхэлсэн 1939 оны 1-р сараас хойш ямар ч тохиолдолд дайсны талын хилийг зөрчихгүй бай! гэсэн тушаал хилийн цэргүүд хүлээж авчээ. Уг тушаалыг монгол цэргүүд маш хатуу мөрдөн биелүүлж байсан юм.

Түүнээс гадна цэргийн гэмт хэрэгтнүүдийг шүүх Олон улсын шүүх хурлын явцад олон баримт бичгүүд гарч байсны дотор японы тагнуулын 23-р ангийн дарга хурандаа Адзумагийн хэрэглэж явсан газрын зураг байв. Уг газрын зураг дээр хилийн шугам монголын талын баримталж байгаагаар тэмдэглэгдсэн байна.⁷ Үүний зэрэгцээ цэргийн прокурорын протоколын № 3024-ын «д» болон «е» зүйл ангид оруулсан японы хоёр экспертын нотолгоонд 1858 оны хятадын түүхийн газрын зураг орсон байв. Энэ газрын зураг дээр монгол, зөвлөлтийн талын баримталж байгаатай яг адилаар хилийн шугам маш тодорхой тэмдэглэгдсэн байв.⁸

Японы дэглэмийн цэрэг дайны түрэмгий төлөвлөгөө Квантуны армийн командлалын газраас тогтмол хэвлэгдэн гарч байсан тэр үеийн газрын зураг дээр тодорхой тусгагдаж байв. Жишээлбэл, 1934 оноос өмнө хэвлэгдсэн газрын зураг дээр Монгол улсын хилийг Халх голоос зүүн тийш гэж тэмдэглэсэн атал 1935 онд хэвлүүлсэн газрын зураг дээр хил тогтоосон шугам нь Халх голын урсгалын дагуу мэтээр зуржээ. Гэтэл 1937 онд Квантуны армийн штабаас гаргасан газрын зураг дээр хилийн шугам өмнөх газрын зурагтай адил Халх голоос зүүн тийш гэж тэмдэглэгджээ.⁹

БНМАУ, Манж-го хоёрын хил японы газрын зураг дээр ингэж тэмдэглэгдсэн төдийгүй үнэн байдал дээрээ өмнө өгүүлсний адил Халх голоос зүүн тийш байсан юм. Япон цэргийн эрх баригчдын хилийн будлиан хэмээн нэрлэж байгаа энэ зохиомол яриа нь бодит байдал дээр зэвсэгт өдөөн хатгалга байсныг нуух аргагүй. Хэрэв энэ «будлианы» явцад япончууд амжилтанд хүрсэн бол японы удирдлага ихээхэн газар нутгийг эзлэн авч цаашид ч их хэмжээний байлдааны үйл ажиллагааг явуулах байсан нь тэдний бэлтгэл ажиллагаанаас тодорхой харагддаг юм.

Манж-го-д цэргийн түшиц газар байгуулагдсаны дараа японы цэрэг монголын хил дээр зэвсэгт өдөөн хатгалга тасралтгүй явуулж эхэлсэн билээ. БНМАУ, Манж-го хоёрын хооронд хил тодорхой бус гэдэг шалтгийг тэд зааж байсан юм. Мэдээжийн хэрэг гол шалтгаан нь БНМАУ, ЗХУ-ын алс дорнод хэсгийг эзлэн түрэмгийлэх гэсэн японы милитарист санаархал байсан билээ. Японд хэвлэгдэн гарсан Халх голын тухай олон номын дотор нэг ч номонд монгол болон бусад орнуудыг эзлэх түрэмгий төлөвлөгөө болсон «Танакагийн меморандум», Монголыг эзлэн авах тухай японы цэргийн болон улс төрийн зүтгэлтнүүдийн хэлсэн үг мэдэгдэл зэргээс иш татаж бичихгүй байгаа нь тэмдэглүүштэй зүйл юм.

1935 оны 1-р сард японы цэргүүд Монголын хилийг зөрчиж Халхын Сүм орчим газрыг булаан авчээ. Өөрийн хил дээр үүссэн түгшүүртэй байдлыг харгалзан, манай засгийн газар Манж-го-гийнхантай хэлэлцээ хийх зорилгоор томилсон н. Самбуу тэргүүтэй монголын засгийн газрын төлөөлөгчид Манжуурийн төмөр замын зөрлөгөд 1935 оны 6-р сарын 2-нд хүрэлцэн очжээ. Хилийн будлианыг зохицуулах хамтарсан комисс байгуулах гэсэн монголын талын саналыг ЗХУ-ын

⁷ К. Танака. Согэн то какүмэй (Тал нутаг ба хувьсгал). 108-р тал.

⁸ Мөн тэнд... 111-112-р тал.

⁹ Ж. Гомикава «Номонхан» Т. 1975 он. 14-р тал.

засгийн газар дэмжиж байв. Гэтэл япон-манжийн тал уг хэлэлцээг бараг хагас жилээр сунжруулж эцсийн эцэст тасалдуулсан билээ. Хилийн будилааныг үүсгэх нь японы командлалаас гаргасан БНМАУ-ын эсрэг түрэмгийлэх ерөнхий стратегийн гол алхам байсан юм. Ийм алхамыг япончууд зүүн хойд хятадыг 1931 онд эзлэн түрэмгийлэхэд ч, 1838 онд зөвлөлтийн эсрэг Хасан нуурын районоор хийсэн өдөөн хатгалгад ч хэрэглэж байсан юм.

1939 оны 4-р сард Квантуны армийн штабаас «Хилийн будлианыг зохицуулах программ» гэгчийг боловсруулан гаргав. Энэ «программыг» зохиогч нь тэр үед Квантуны армийн штабын дарга байсан Цужи Масанобу байжээ. Ж. Гомикавагийн номонд уг программыг бүхлээр нь оруулжээ. Үүнд: «хилийн шугам тодорхой байгаа тохиолдолд бид (японы цэрэг—Г.З.) дайсныг довтолуулахгүйгээр урагшаа давших үүрэгтэй»¹⁰ гээд уг программын 3-р зүйлд: «Хилийн шугам тодорхой бус тохиолдолд (японы талын) зохих удирдлага нь өөрсдөө хилийн шугамыг тогтоох ёстой...» гэжээ. 4-р зүйлд: «Хэрэв мөргөлдөөн гарвал тэргүүн шугамын анги нэгтгэлүүд зоригтойгоор урагш довтолбол зохино»¹¹ гэж тэмдэглэжээ.

Энэ программ нь БНМАУ-д довтолох гэсэн Квантуны армийн зорилгыг маш тодорхой харуулж байна.

Японы түүх бичлэгт Халх голын тулалдааныг «Номонханы хэрэг явдал» гэж нэрлэдэг. Номонхан бол Халх голын эргийн ойролцоо Хайласт голоос хойш оршдог газрын нэр юм. Японыхон «Номонханы хэрэг явдал» цаг хугацааны хувьд хоёр хувааж Японы цэрэг БНМАУ-ын газар нутагт халдан довтолсон 1939 оны 5-р сарын түрэмгий ажиллагааг 1-р «хэрэг явдал» гэж үздэг.

5-р сарын 29-нд монгол—зөвлөлтийн цэргүүд түрэмгийлэгчдийг бут цохиход япончууд Манж-го-гийн нутаг руу ухарч 7-р сарын эхээр шинэ довтолгоон хийхээр бэлтгэж эхэлсэн үеийг «Номонханы 2-р хэрэг явдал» гэж япончууд үзэж байна. Ингэж хуваах нь санамсаргүй биш бөгөөд 1-рт түрэмгийллийн шинж чанарыг зориуд алдагдуулж уг «хэрэг явдал» нь Монголыг эзлэх гэсэн японы стратегийн ерөнхий төлөвлөгөөнөөс гадна болсон зүйл мэтээр дүрслэхийг оролдох, 2-рт, Халх голын тулалдааныг хүн болоод материалын асар их хохиролтой орчин үеийн дайн биш зөвхөн удаа дараагийн орон нутгийн чанартай хилийн будлиан мэтээр нотлох, 3-рт дайны үйл ажиллагаа зогссон нь дайнд ялагдал хүлээснээс болсон биш харин хилийн будлианыг зохицуулснаар шийдвэрлэгдсэн гэдэг ойлголт өгөхөд чиглэгджээ. Япончууд хэрэг явдлыг өгүүлэхдээ түрэмгийлэл эхэлсэн яг тэр үеийг дурьдахгүйгээр зөвхөн 7, 8-р сарын хэрэг явдлыг өдөр бүрээр нь шахуу бичиж байна. Японы уншигчид Номонханы хэрэг явдлын зөвхөн 2-рыг л мэддэг юм. 2-р явдлыг нь Хасан нуурын орчим болсон мөргөлдөөнтэй адил нэг хилийн будилан гэж үздэг.¹² 1939 оны 8-р сарын эцэст японы түрэмгийлэгчдийг бут цохисон гол тулалдааныг, өөрөөр хэлбэл монгол—зөвлөлтийн хамтарсан армийн ялалтаар байлдаан дууссан тухай японы сурвалж бичгүүдэд бараг дурсахгүй буюу дурссан ч түүхэн үнэнийг гуйвуулж байна. Тухайлбал «Тоё» сэтгүүлд Гитлерийн Герман ЗХУ-ын эсрэг дайнд илэрхий бэлтгэж, Европ тивд олон улсын байдал ихээхэн хурцадсаны улмаас ЗХУ арга буюу дайны галыг зогсоосон мэтээр бичиж байжээ.¹³

¹⁰ Ж. Гомикава. Мөн зохиол. 13-р тал.

¹¹ Э. Тарада «Номонхан-но синсо» (Номонханы тухай үнэн) 1981, 19-р тал.

¹² Т. Одзава. Номонхан дайны тэмдэглэлүүд. 30-р тал.

¹³ «Тоё» сэтгүүл. 1934 оны 11-р сар.

Халх голын тулалдааныг иймэрхүү бодит биш, ямар ч үндэсгүйгээр үнэлэх явдал өнөөгийн Японд хэвлэгдэн гарч буй олонхи ном зохиолд давамгайлж байна. Милитарист Японы түрэмгий түүхийг бүрхэгдүүлэх, дэлхийн II дайныг дэгдээсэн болон түүнд ялагдсаны учир холбогдлыг будлиантуулах нь хөрөнгөтний үзэл суртлын бүрэлдүүн хэсэг бөгөөд энэ нь Японд милитаризмыг дахин сэргээж байгаа өнөөгийн засгийн газрын бодлоготой салшгүй холбоотой юм. Үүнийг тодруулах нэг жишээ авч үзье. Японыхон Хядадад түрэмгийлсэн бодит түүхийг гуйвуулан засварласан сургуулийн сурах бичгүүд хэвлэсэн нь олон улсын хэмжээний маргаан болж хувирсныг хэлэх хэрэгтэй.

Халх голын хэрэг явдлын тухай Японы ном зохиол, дурьдатгалуудад дэлгэрэнгүй бичиж олон төрлийн газрын зураг, штабын мэдээ, фото зураг оруулж байна. Харин БНМАУ, Япон болон Алс Дорнод дахь олон улсын харилцааны түүхэнд Халх голын тулалдаан ямар байр суурь эзэлдэг тухай гол асуудлыг хөндөхөөс тэд зайлсхийж байна.

Түүхэн үйл явдалд задлан шинжилгээ хийхгүй, асуудалд ямар ч ул үндэсгүй хандах явдал өнөөгийн Япон дахь хөрөнгөтний үзэл суртлын нэг илрэл болж байна. Ийм учраас халхын голын түүхийг бичихдээ тэд Япон ялагдал хүлээсэн биш, харин хилийн будлианыг зохицуулснаар байлдааны ажиллагаа зогссон хэмээн японы хэвлэлд бичиж байна. Ж. Гомикава ноёрхож буй энэ хандлагаас арай ялгаатай дүгнэлт хийж үзэж, <<Номонханы хэрэг явдлыг>> Номхон далайд бага дайн байсан хэмээн үзэж, энэ дайн Номхон далайд Япон ялагдахын урьдчилсан дохио болсон, тухайлбал «Номонханы тал газарт их буу дуугарсан нь Японы хувь заяаг урьдчилан шийдсэн хэрэг байв»¹⁴ гэж бичжээ. 30-аад онд ЗХУ-ыг эзлэн түрэмгийлэх төлөвлөгөөнд олон улсын империализм, фашистын Германы зэрэгцээ милитарист Япон чухал үүрэг гүйцэтгэж байсан юм. Японы түрэмгий хүчнүүд Баруун Европын болон АНУ-ын эрх баригчдаас өөгшүүлэн дэмжсэний харгайгаар Коминтерны эсрэг тэдэнтэй гэрээ байгуулж Манжуурыг эзэлж улмаар ЗХУ-ын эсрэг довтолоход хүчтэй бэлтгэж байв. Тэд БНМАУ-ын нутаг дэвсгэрийг өөрсдийн түрэмгий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамгийн ашигтай түшиц газар гэж үзэж байлаа.

Японы цэргийн командлал Сибирийн төмөр замыг таслах гэж санаархаж байсан нь ЗХУ-ын Европын хэсгээс Зөвлөлтийн Алс Дорнодод зэвсэгт хүчээ шилжүүлэн байрлуулах боломжгүй болсон гэсэн оролдлого байв.¹⁵ Үүний зэрэгцээ Японы милитаристууд зөвлөлтийн Уссури, Хабаровск болон Амар мөрний чиглэлээр халдан довтолж Уссурийск, Владивосток, Иман зэрэг хотуудыг «Цахилгаанчилсан булаан эзлэлтээр» эзэлсний дараа Хабаровск, Благовещенск, Куйбышевка хотуудыг эзлэх төлөвлөгөөтэй байлаа.¹⁶

Халх голд япончууд ялагдсан нь японы удирдах харгис бүлгийн төлөвлөгөөг нурааж, тэдний түрэмгий санаархлыг их хэмжээгээр бууруулсан бөгөөд энэ нь дэлхийн II дайнд Япон идэвхтэй оролцох явдлыг бараг 2 жилээр хойшлуулсан юм. Халх голын хэрэг явдал нь Японы удирдах харгис бүлэг ЗХУ-ын эсрэг дайнд орох гэсэн санаархлаасаа татгалзахад арга буюу хүргэсэн юм.

¹⁴ Ж. Гомикава. Дурьдсан зохиол. 11-р тал.

¹⁵ «Международные отношения на Дальнем Востоке» 2-р ном. 1917-1945., М. 1973, 144-р тал.

¹⁶ Эллиот Рувельт. Его глазами. М., 1947, 69-р тал.

Халх голын орчимд японы түрэмгийлэгчдийг Зөвлөлт-Монголын ах дүү армийн хамтарсан хүчээр няцаасан нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд их ач холбогдолтой болж, 1936 онд байгуулсан Монгол—зөвлөлтийн протокол гэрээ нь БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлын баталгаа болсныг харуулсан юм.

Халх голын районд японы арми бут цохигдсон нь зөвхөн японы төдийгүй, японыг энэ түрэмгийлэлд турхирч байсан олон улсын империалист харгис хүчинд томоохон цохилт болсон юм.

Халх голын тулалдааныг японы ном зохиолд субъектив буюу бодит биш байдлаар дүгнэж байгаа нь японы зохиогчдын үзэл суртал, байр суурьтай холбоотой юм. Алс Дорнод дахь дайны түүхэн баримтыг гуйвуулан японы милитаризмыг сэргээх үзэл санаагаар олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлэх хандлага, «Номонханы нийгэмлэг» гэх мэтийн гэмт нийгэмлэгүүдийн ил үйл ажиллагаа, тэрчлэн цэргийн гэмт хэрэгтнүүдийг албан ёсоор дурсах болсон зэрэг нь японы одоогийн засаг захиргааны аюултай чиг шугам мөн бөгөөд Японд милитаризм болон самуурайн үзэл санааг сэргээх зорилгоо хэрэгжүүлж байгаагийн баримт мөн.

БНМАУ-ын түүхийг түүний дотор Халх голын орчим болсон дайны түүхийг өчүүхэн төдий ч гэсэн гуйвуулахыг бид зөвшөөрөхгүй. Энэ нь манай түүхийн шинжлэх ухааны өнөөгийн чухал зорилтуудын нэг даруй мөн.

ЯПОНСКИЕ ПУБЛИКАЦИИ О ВОЙНЕ У ХАЛХИН-ГОЛА

(Резюме)

Г. Зориг

Победа советско-монгольских войск у Халхин-Гола, 45-ю годовщину которой монгольский народ отмечает в этом году, явилась одним из крупных событий новейшей истории МНР. Она продемонстрировала интернациональную и классовую сплоченность СССР и Монголии перед лицом империалистической агрессии, стала доказательством нерушимой братской дружбы наших народов.

В японской историографии большинство работ о событиях у Халхин-Гола представляет собою мемуарную литературу и отдельные книги, в которых не говорится об истинных причинах японской агрессии, события подаются оторванными от милитаристского внешне-политического курса японского правительства и общей международной обстановки на Дальнем Востоке, поражение рассматривается как следствие недооценки противника, слабых взаимодействий и отсутствия взаимопонимания между штабами Квантунской армии и Главным командованием. Сражение у Халхин-Гола в ней изображается как пограничный инцидент, а не современная война с огромными людскими и материальными потерями.

В книгах, изданных в Японии, войну у Халхин-гола называют «Номонханским инцидентом», который по времени разделяют на два отдельных периода. Это деление имеет особый смысл: во-первых,

сами события теряют целостность и представляют оторванными друг от друга, вне общего стратегического плана Японии по завоеванию Монголии. Во-вторых, чтобы явно принизить значение этой войны с участием большого количества техники и авиации ее описывают как серию пограничных инцидентов.

Трактовка подобного рода прямо фальсифицирует историю МНР и международных отношений на Дальнем Востоке. Издаваемая массовым тиражом, она призвана заретушировать историю милитаристской Японии, принизить значение поражения агрессора во второй мировой войне. Это следует рассматривать в прямой связи с нынешним курсом правительства Японии, пытающегося возродить в стране милитаризм и самурайский дух.